



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 503

Улаанбаатар хот

Г Аргачлал батлах тухай Г

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.23 дахь заалт, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 132 дугаар тогтоолоор баталсан Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний аудитор, эрчим хүчний аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Эрчим хүчний аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг аргачлалын дагуу үнэлж, тогтоосон хугацаанд тайлagnаж ажиллахыг Эрчим хүч хэмнэлтийн газар (Ц.Атаржаргал)-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА  
ЗОХИЦУУЛАГЧ  
ЗОХИЦУУЛАГЧ  
ЗОХИЦУУЛАГЧ  
ЗОХИЦУУЛАГЧ

С.Түвшинчулун  
П.Товуудорж  
Л.Дашмягмаржав  
Э.Самдан  
Ц.Норовжамц

Э.ТУВШИНЧУЛУУН  
П.ТОВУУДОРЖ  
Л.ДАШМЯГМАРЖАВ  
Э.САМДАН  
Ц.НОРОВЖАМЦ



## ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТОР, ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Эрчим хүчиний аудитор (цаашид “аудитор” гэх), Эрчим хүчиний аудитын байгууллага (цаашид “аудитын байгууллага” гэх)-ын жилийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэхэд энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Энэ аргачлалын зорилго нь аудитор, аудитын байгууллагад тавигдах шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүн, хариуцлагыг дээшлүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

1.3. Үнэлж, дүгнэх үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид хараат бус, үр дүнд чиглэсэн, баримт, нотолгоонд тулгуурлах зарчмыг баримтална.

1.4. Энэ аргачлалын 1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, эрчим хүчиний аудитын MNS EN 16247 стандартыг удирдлага болгоно.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх ажлын хүрээнд дараах үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

2.1.1. Аудитор, аудитын байгууллагын гүйцэтгэсэн аудитын тайлангийн стандартын нийцлийг үнэлэх;

2.1.2. Аудитор, аудитын байгууллагад тавигдах шаардлага, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, тэдгээрийн нийцлийг үнэлэх;

2.1.3. Аудитын үйл ажиллагаатай холбоотой үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагааг авах.

2.2. Үнэлгээнд хамаарах баримт, материалыг хүлээн авах, бүртгэх, үнэлэх, мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлыг энэ аргачлалын хавсралт маягтын дагуу тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн хийж гүйцэтгэнэ.

2.3. Тайлан, мэдээллийг хүлээн авч үнэлэх үйл ажиллагаанд Хорооны Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан нэгжийн дарга хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

2.4. Аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүнг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Эрчим хүчиний зохицуулах хорооны хуралд танилцуулж дүнг баталгаажуулна.

2.5. Аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүнг Эрчим хүчиний зохицуулах хорооны хуралд танилцуулж дүнг баталгаажуулахаас өмнө аудитор, аудитын байгууллагад мэдэгдэнэ.

### ГУРАВ. МЭДЭЭ ТАЙЛАН ИРҮҮЛЭХ, ХҮЛЭЭН АВАХ

3.1. Аудитор, аудитын байгууллага нь жилийн үйл ажиллагааны үнэлгээнд хамаарах тайлан, мэдээ, баримт, материалыг тогтоосон хугацаанд хавсралт

маягтын дагуу гаргаж цахимаар/бичгээр Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлнэ.

3.1.1. Жилийн үйл ажиллагааны тайланг /Хавсралт-4/ загварын дагуу дараа жилийн нэгдүгээр сард;

3.1.2. Аудитын мэдээг тухай бүр /Хавсралт-5/ маягтын дагуу үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор;

3.1.3. Гүйцэтгэсэн аудитын мэдээг тухай бүр /Хавсралт-6/ маягтын дагуу үйлчлүүлэгчид аудитын тайланг хүлээлгэн өгч гэрээг дүгнэснээс хойш 14 хоногийн дотор.

3.2. Аудитор, аудитын байгууллага нь тайлан болон холбогдох мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

## ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

4.1. Аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг энэ аргачлалын 2.4-т заасан бүрдэлийн дагуу үнэлнэ.

4.2. Энэ аргачлалын 2.1.1-д заасан үнэлгээ нь тухай жилд гүйцэтгэсэн нийт аудитын тайлангийн үнэлгээний арифметик дунджаар тооцогдох ба жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 50 хувь байна.

4.2.1. Аудитын тайланг үнэлэхдээ Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”, Эрчим хүчний аудитын MNS EN 16247 стандарттаар тодорхойлсон шаардлага, бүрдэл хангагдсан эсэхийг хавсралт-1 маягтаар тодорхойлсон онооны системээр үнэлнэ.

4.2.2. Аудитор, аудитын байгууллага нь Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон эрх, магадлан итгэмжлэлийн төрлийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгээгүй бол тухайн тайланг “Тэг” гэж үнэлнэ.

4.3. Энэ аргачлалын 2.1.2-т заасан үнэлгээ нь аудитор, аудитын байгууллагаас /хавсралт-4, хавсралт-5, хавсралт-6/ маягтын дагуу ирүүлсэн тайлан, мэдээгээр тодорхойлогдох ба жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 30 хувь байна.

4.3.1. Аудитор, аудитын байгууллагад тавигдах шаардлага, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, тэдгээрийн нийцлийг үнэлэхдээ Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар тогтоосон шаардлага хангагдсан эсэхийг /хавсралт-2/ маягтын дагуу онооны системээр үнэлнэ.

4.4. Энэ аргачлалын 2.1.3-т заасан үнэлгээ нь үйлчлүүлэгчийн сэтгэл хамнамжийн судалгааны асуулгын нийлбэрийн дундаж оноогоор тодорхойлогдох ба жилийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувийн жин 20 хувь байна.

4.4.1. Үйлчлүүлэгчийн сэтгэл хамнамжийн судалгааг энэ аргачлалын /хавсралт-3/ маягтын дагуу авна.

4.5. Энэ аргачлалын 4.2, 4.3, 4.4-т заасан үнэлгээгээр авсан нийт оноог тухайн үзүүлэлтийн авбал зохих оноонд харьцуулан хувиар илэрхийлэх бөгөөд жилийн үйл ажиллагааны үнэлгээг үзүүлэлтүүдийн нийлбэрээр дараах байдлаар дүгнэнэ.

Гүйцэтгэл (%)	Үнэлгээ
90-ээс 100 хүртэл	Хангалттай сайн
75-аас 90 хүртэл	Сайн
60-аас 75 хүртэл	Дунд
60 хүртэл	Хангалтгүй

4.6. Аудитор, аудитын байгууллага нь энэ аргачлалын 3.1-д заасан мэдээллийг, тогтоосон хугацаанд ирүүлж тайлагнаагүй болон тухайн жилд Эрчим хүчний зохицуулах хорооноос олгосон эрх, магадлан итгэмжлэлийн хүрээнд эрчим хүчний аудитын үйл ажиллагаа явуулаагүй бол биелэлтийг “Хангалтгүй” гэж үнэлнэ.

#### **ТАБ. ҮР ДҮНГ МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ, МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ**

5.1. Энэ аргачлалын 2.5-д заасан шийдвэрийг үндэслэн аудитор, аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дутагдал зөрчлийг арилгах, чанар, үр дүнг сайжруулахаад чиглэсэн үүрэг даалгавар, санал, зөвлөмжийг аудитор, аудитын байгууллагад хүргүүлнэ.

5.2. Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийн магадлан итгэмжлэх журам”-д заасны дагуу аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээний дүнг Хорооны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж болно.

Эрчим хүчний аудитор, аудитын  
байгууллагын жилийн үйл ажиллагааг  
үнэлэх аргачлалын нэгдүгээр хавсралт

9022070691  
9128808 - СБА10523

### Эрчим хүчний аудитын тайланг үнэлэх маягт

№	Шалгуур	Аудитын төрөл	
		Анхан шатны	Хэсэгчилсэн/дэлгэрэнгүй
<b>Стандартын шаардлага хангагдсан бол-1, Үгүй бол-0 оноо өгнө.</b>			
	<b>Ерөнхий хэсэг<sup>1</sup></b>	<b>3</b>	<b>3</b>
1	1.1 Гарчиг /Тайлангийн агуулга, товьёог/	1	1
	1.2 Товчилсон үг, хүснэгт, зураг, график /Тэдгээрийн жагсаалт, товьёог/	1	1
	1.3 Хавсралт /Тайланд хамаарах холбогдох тооцоолол, судалгаа, танилцуулга, материалуудын жагсаалт, товьёог/	1	1
2	<b>Танилцуулга хэсэг</b>	<b>3</b>	<b>3</b>
	2.1 Хураангуй /Тайлангийн хураангуй хэсэг/	1	1
	2.2 Үр ашгийг сайжруулах боломжийг тодорхойлж, эрэмбэлэх	1	1
	2.3 Санал болгож буй арга хэмжээг тодорхойлох	1	1
3	<b>Үндэслэл хэсэг</b>	<b>5</b>	<b>5</b>
	3.1 Аудит хийсэн байгууллага, аудиторын танилцуулга	1	1
	3.2 Аудиторууд нь тухайн аудитын аль хэсгийг хийсэн талаарх мэдээлэл	1	1
	3.3 Аудитын нөхцөл	1	1
	3.4 Аудит хийсэн объект, хэсгийн танилцуулга	1	1
	3.5 Ашигласан норм, дүрэм, журам, стандартын тухай	1	1
4	<b>Эрчим хүчний аудит</b>	<b>4</b>	<b>7</b>
	4.1 Төрөл, хамрах хүрээ, нарийвчлал, хугацаа, төлөвлөгөө	1	1
	4.2 Өгөгдөл мэдээлэл цуглувсан байдал	1	1
	4.3 Хэмжилт хийх шаардлага, нөхцөл байдал	-	1
	4.4 Хэмжилт хийсэн мэдээлэл, утгуудын талаарх мэдээлэл	-	1
	4.5 Хэмжилт хийсэн багаж төхөөрөмжийн талаарх мэдээлэл/хуулбар	-	1
	4.6 Өгөгдөл, мэдээлэл, хэмжилтэд хийсэн дүн шинжилгээ	1	1
	4.7 Үр ашгийг сайжруулах арга хэмжээний эрэмбийг тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүд	1	1
5	<b>Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх боломж</b>	<b>4</b>	<b>6</b>
	5.1 Санал болгосон арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө	1	1
	5.2 Тооцоонд ашигласан таамаглал, зөвлөмжийн нарийвчлал	1	1
	5.3 Санхүүжилт, хөрөнгө оруулалтын мэдээлэл/татаас,	1	1

<sup>1</sup> Ерөнхий хэсэг нь аудитын тайлангийн гарчиг, товчилсон үг, хүснэгт, зураг, гарафик болон хавсралт гэсэн дэд хэсгээс бүрдэх ба гарчиг хэсэгт тухайн тайлангийн агууллын товьёог, хавсралт хэсэгт тухайн тайланда хамаарах холбогдох танилцуулга, тооцоолол, бусад нэмэлт материал, тэдгээрийн жагсаалтыг тус тус оруулна.

	зээл		
5.4	Эдийн засгийн үр өгөөжийн талаарх тооцоо, дүгнэлт	-	1
5.5	Санал болгож буй арга хэмжээний уялдаа хамаарал	-	1
5.6	Зөвлөмжийг хэрэгжүүлснээр гарах хэмнэлтийг тодорхойлсон тооцооны арга, аргачлалын тухай	-	1
5.7	Дараагийн аудит, нарийвчилсан хэмжилт, судалгаа хийх шаардлагыг тодорхойлсон байдал	1	-
<b>6</b>	<b>Ерөнхий дүгнэлт</b>	<b>1</b>	<b>1</b>
<b>Нийт оноо</b>		<b>20</b>	<b>25</b>

**Хянасан:**

Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан  
нэгжийн дарга: Овог нэр: ..... /Гарын сэг/  
Он сар өдөр: .....

**Үнэлсэн:**

Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан нэгжийн тухайн асуудлыг  
хариуцсан мэргэжилтэн: Овог нэр: ..... /Гарын үсэг/  
Он сар өдөр: .....



Эрчим хүчин аудитор, аудитын  
байгууллагын жилийн үйл ажиллагааг  
үнэлэх аргачлалын хоёрдугаар хавсралт

**Аудитор, аудитын байгууллагад тавигдах шаардлага, холбогдох хууль,  
тогтоомжийн хэрэгжилт, тэдгээрийн нийцлийг үнэлэх маягт**

№	Шалгуур	Оноо	
		Аудитор	Аудитын байгууллага
<i>Холбогдох тайлан, мэдээгээр нотлогдож байгаа бол-1, үйгүй бол-0 оноо өгнө.</i>			
1	<b>Магадлан итгэмжлэлийн төрөл, олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байдал</b>	1	3
	1.1 Аудитын байгууллага нь магадлан итгэмжлэлийн төрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байх	-	1
	1.2 Аудитор нь олгосон эрхийн хүрээнд аудит хийсэн байх	1	1
	1.3 Аудитын үйл ажиллагаанд санал болгосон аудиторуудын оролцоо бүрэн хангагдсан байх	-	1
2	<b>Тайлан, мэдээг хугацаандаа ирүүлж тайлагнасан байдал</b>	3	3
	2.1 Жилийн үйл ажиллагааны тайланг ирүүлсэн байх	1	1
	2.2 Аудитын мэдээг тогтоосон хугацаанд ирүүлсэн байх	1	1
	2.3 Гүйцэтгэсэн аудитын мэдээг ирүүлсэн байх	1	1
3	<b>Аудитор, аудитын байгууллагад тавигдах шаардлага, тэдгээрийн нийцэл</b>	6	9
	3.1 З-аас доошгүй аудитортой байх	-	1
	3.2 Аудиторууд бусад байгуулагад аудитороор хавсран, хослон ажил эрхэлдэггүй байх	-	1
	3.3 Давтан болон мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх	1	1
	3.4 Программ хангамж, хэмжүүрийн болон бусад багаж хэрэгслийн бүрдэлтэй байх	1	1
	3.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг мөрдсөн байх	-	1
	3.6 Мэргэжлийн ёс зүйтэй холбоотой гомдол гараагүй байх	1	1
	3.7 Үйлчилгээний чанартай холбоотой гомдол, маргаан гараагүй байх	1	1
	3.8 Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж чиглэлийг биелүүлсэн байх	1	1
	3.9 Эрчим хүчиний зохицуулах хорооноос зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байдал	1	1
<b>Нийт оноо</b>		<b>10</b>	<b>15</b>

**Хянасан:**

Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан  
нэгжийн дарга: Овог нэр: ..... /Гарын сэг/

Он сар өдөр: .....

**Үнэлсэн:**

Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан нэгжийн тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн: Овог нэр:...../Гарын үсэг/

Он сар өдөр: .....

**Жич.** Энэхүү үнэлгээг аудитор, аудитын байгууллагаас энэ аргачлалын хавсралт-4 загварын дагуу ирүүлсэн жилийн үйл ажиллагааны тайлан, мэдээнд тулгуурлан гүйцэтгэнэ.

Эрчим хүчний аудитор, аудитын  
байгууллагын жилийн үйл ажиллагааг  
үнэлэх аргачлалын гуравдугаар хавсралт

9022070691  
9128808 СВА10523

## ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ АСУУЛГЫН МАЯГТ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.7, “Эрчим хүчний аудитын байгууллага болон мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.3 дах заалтыг тус тус удирдлага болгов.

### Мэдээлэл

Аудитын үйлчилгээ авсан байгууллагын нэр:

.....

Үйлчилгээ үзүүлсэн аудитор, байгууллагын нэр:

.....

Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл эрчим хүчний хэмнэлт, үр ашиг хариуцсан ажилтны мэдээлэл

Овог нэр: ..... Албан тушаал:

Аудитын гэрээний хугацаа

.....

Аудитын төрөл

Утас: ..... Имэйл: .....

Аудитын үйлчилгээний хамрах хүрээ

Анхан шатны /Хэсэгчилсэн/  
Дэлгэрэнгүй  
Хэсэг, нэгж, цех, технологийн  
процесс

### 1. Аудитын үйлчилгээний чанар, мэргэшлийн түвшин, ур чадвар

**Үнэлгээ:** Mash сайн-3, Хангальтай-2, Дунд-1, Хангальгүй-0

Үнэлэх үзүүлэлтүүд/ Дээд үнэлгээ 30	Үнэлгээ
1. Ажлын байранд үзлэг хийж, тодруулга, ярилцлага авсан байдал	
2. Хэмжих хэрэгсэл ашиглан хэмжилт, туршилт хийсэн байдал	
3. Өгөгдөл мэдээлэл, хэмжилтийн үр дүнг боловсруулж, дүгнэсэн байдал	
4. Аудитын зөвлөмж нь үндэслэл, тооцоо, нотолгоонд суурилсан эсэх	
5. Зөвлөмжид тусгагдсан арга хэмжээг бодитоор хэрэгжүүлж үр дүн гаргах боломжтой эсэх	
6. Аудитын үр дүн, тайлан, зөвлөмжийг танилцуулсан байдал	
7.а. <u>Анхан шатны аудит-</u> Шууд хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашид нарийвчилсан судалгаа хийх хэрэгцээ шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон байдал	
7.6. <u>Хэсэгчилсэн, дэлгэрэнгүй аудит-</u> Шаардлагатай хөрөнгө оруулалт, түүний өгөөжийг тооцоолсон байдал	
8. Санал болгосон аудитын баг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажилласан эсэх	
9. Аудиторын ёс зүй, харилцааны ур чадвар	
10. Ажлын даалгавар бүрэн биелсэн эсэх	
<b>Дүн</b>	

## 2. Санал, шүүмж

Аудитын байгууллага/аудиторын үзүүлсэн аудитын үйлчилгээг цаашид сайжруулах санал, шүүмж байгаа бол тодорхой бичнэ үү.

.....  
.....

**Судалгаанд оролцсон:**

Ажилтны нэр, албан тушаал: ..... /гарын үсэг/ ..... /утасны дугаар/

Жич. Энэхүү судалгааг аудитын үйлчилгээний чанарыг үнэлэх зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооноос авч байгаа бөгөөд эрчим хүчний аудитор/аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэхэд судалгааны дүнг харгалзан авч үзнэ. Судалгаанд оролцох хүний тоог хязгаарлаагүй болно.

Эрчим хүчний аудитор, аудитын  
байгууллагын жилийн үйл ажиллагааг  
үнэлэх аргачлалын дөрөвдүгээр хавсралт

9022070691  
9128808 - СВА10523

**АУДИТОР/АУДИТЫН БАЙГУУЛЛАГА /...../-ЫН .... ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ХҮЛЭЭН АВСАН:**

ЭХХГ-ЫН тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн:

Овог нэг:...../...../.....

Он сар өдөр:.....

**ТАНИЛЦСАН/ХЯНАСАН:**

Аудитын байгууллагын удирдлага

1. Овог нэр ..... /Гарын үсэг/ Тамга/

**БОЛОВСРУУЛСАН.**

1. Эрчим хүчний аудитор..... /Гарын үсэг/
2. .....

## **Жилийн үйл ажиллагааны тайлангийн агуулга**

*Аудитор, аудитын байгууллагын тайлант онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг дараах байдлаар тусгана.*

### **1. АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:**

- Олгосон эрх, магадлан итгэмжлэлийн хүрээнд явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх өрөнхий мэдээлэл;
- Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл

### **2. АУДИТОРУУДЫН УР ЧАДВАР, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:**

- Аудиторууд сургалтад хамрагдсан байдал
- Бусад мэргэжилтэй боловсон хүчний сургалт, хөгжил
- Аудитын үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамж, хэмжих багаж хэрэгсэл, тэдгээрийг сайжруулсан байдал
- Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулсан бусад арга хэмжээнд оролцсон байдал

### **3. ХУУЛЬ, ЖУРАМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ, ХОРООНООС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ЧИГЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН БИЕЛЭЛТ:**

- Олгосон эрх, магадлан итгэмжлэлийн хүрээнд тавигдах шаардлага, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, баримтыг хавсаргана.
- Хорооноос өгсөн зөвлөмж, үүрэг даалгавар, түүний хэрэгжилтийн биелэлт

### **4. ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

#### **5. ДАРАА ЖИЛИЙН ЗОРИЛТ:**

#### **6. ХАВСРАЛТ /Жилийн үйл ажиллагааны тайланд хамаарах баримт, мэдээлэл/**

Эрчим хүчний аудитор, аудитын  
байгууллагын жилийн уйл ажиллагааг  
үнэлэх аргачлалын тавдугаар хавсралт

9022070691  
9128808 - СБА10523

## АУДИТЫН МЭДЭЭ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 4.1-дэх заалтыг тус тус удирдлага болгов.

Үйлчлүүлэгчийн мэдээлэл		
Хуулийн этгээдийн нэр:		
Хуулийн этгээдийн хаяг, байршил:		
Хуулиар үүрэг хүлээсэн хэрэглэгч мөн эсэх:		Тийм / Үгүй
Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл тухайн асуудал хариуцсан холбогдох ажилтны мэдээлэл:		Нэр: Албан тушаал: Утас: Имэйл:
Аудитор/ Аудитын байгууллагын мэдээлэл		
Аудитын байгууллагын нэр:		
Холбоо барих утас, Имэйл:		
Аудитын багийн ахлагчийн нэр:		
Үйлчилгээ үзүүлэх аудиторууд:	Аудитын чиглэл	Аудиторын нэр
	Цахилгаан	Овог, нэр
	Дулаан/ уур	Овог, нэр
	Барилга	Овог, нэр
Эрчим хүчний аудитын үйлчилгээний мэдээлэл		
Аудитын гэрээний дугаар:		
Аудитын гэрээний хугацаа:		
Гүйцэтгэх аудитын төрөл:		Анхан шатны /Хэсэгчилсэн/ Дэлгэрэнгүй аудит
Аудитын үйлчилгээний хамрах хүрээ:		Ажлын даалгаерын дагуу аудит хийх алба, хэлтэс, нэгж, цех, технологийн процесс
Аудит хийсэн объектын хаяг, байршил:		

### Баталгаажуулсан:

Аудитор/ Аудитын байгууллагын удирдлага/  
..... (нэр, гарын үсэг, тамга)

### Хүлээн авсан:

Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан нэгжийн тухайн асуудлыг хариуцсан  
мэргэжилтэн: Овог нэр:...../Гарын үсэг/

Он сар өдөр: .....

Жич. Энэхүү мэдээнд аудитын гэрээ, аудит хийх төлөвлөгөө, ажлын даалгаерын  
хуулбарыг хавсаргаж ирүүлнэ.

Эрчим хүчний аудитор, аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааг үнэлэх аргачлалын зургаадугаар хавсралт

9022870691  
9128808 - СБА10523

## ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН МЭДЭЭ

Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний аудит хийх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.2.7-д заалтыг тус тус удирдлага болгов.

Аудитын тайлангийн мэдээлэл	
Аудитын тайлан, зөвлөмжийг үйлчлүүлэгчид тайлagnаж танилцуулсан эсэх	Тийм, Огноо 20... оны ... сарын ... өдөр Үгүй
Аудитын тайлан, зөвлөмжийг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгсөн огноо	20... оны ... сарын ... өдөр
Аудитын тайланг боловсруулж хүлээлгэн өгсөн	
Аудитын байгууллагын нэр	
Холбоо барих утас, Имэйл	
Аудитын багийн ахлагч, аудитор, бусад ажилтнууд	<p>Нэр : ..... Утас:  ..... (гарын үсэг, тамга)  Бусад ажилтнууд</p> <p>Нэр : ..... Утас:  ..... (гарын үсэг, тамга)</p>
Эрчим хүчний аудитын үйлчилгээний мэдээлэл	
Байгууллагын удирдлага	<p>Нэр : ..... Утас:  ..... Албан тушаал:  ..... (гарын үсэг, тамга)</p>
Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн асуудлыг голлон хариуцах газар, хэлтсийн удирдлага	<p>Нэр : ..... Утас:  ..... Албан тушаал:  ..... (гарын үсэг, тамга)</p>
Эрчим хүч хэмнэлтийн менежер эсхүл холбогдох ажилтан	<p>Нэр : ..... Утас:  ..... Албан тушаал:  ..... (гарын үсэг, тамга)</p>

### Баталгаажуулсан:

Аудитор/ Аудитын байгууллагын удирдлага:  
..... (нэр, гарын үсэг, тамга)

### Хүлээн авсан:

Эрчим хүч хэмнэлтийн асуудал хариуцсан нэгжийн тухайн асуудлыг хариуцсан

мэргэжилтэн: Овог нэр:...../Гарын үсэг/

Он сар өдөр: .....

Жич. Энэхүү мэдээнд аудитын гэрээ дүгнэсэн актыг хавсаргаж ирүүлнэ.